

## АНУ-ЫН УРАН ЗОХИОЛЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

*М.Хурметхан\**

Европоос Хойд Америкт ирсэн анхны судлаач шинжээч ба суурьшигчид тус тивийн байгалийн сайхан, ер бусын ургамал амьтан болон уугуул нутгийн улаан арьстны ёс заншлын талаар үзэж харснаа хуучин Европ руу буцаж мэдээлэхээс хэтрэхгүй байлаа. Үнэндээ анхны Америкийн уран зохиол болох уг нутгийн уламжлалт баялаг ардын аман зохиолыг тэмдэглэж авч байсангүй ажээ.

### Бодит эхлэл

1600 оны эхний жилүүдэд колончлогчид өөрсдийн амьдрал, шинэ нутгийнхаа тухай Европт буй найз нөхдөө танилцуулах зорилгоор тэмдэглэл хөтөлж байлаа. Jamestown /Virginia/ -ыг үүсгэн байгуулагч цэргийн ахмад Жон Смит /1580-1631/ өөрийн оршин суусан тосгоны эдийн засаг, улс төрийн тогтолцооны талаар ном бичиж байсан. Массачусет Бай Колоны захирагч Уллиям Брадфорд /1590-1651/ Англи, Голландаас гарч цагаачлан ирсэн шашны эрх чөлөөг хайгчдын туршлагыг цаасан дээр бичин буулгаж байлаа. Түүний түүх нь Плеймоутын тариалангийн талбайн хүнд хэцүү нөхцөл энэхүү байдлыг шашны зүгээс өөрийн бодол санаагаар тайлбарлахад чиглэгдэж байв. Ийнхүү тус нутагт оршин суугчдын дунд удаан хугацааны туршид уран сэтгэмжтэй уран зохиол бичигдэж байсангүй. Анхандаа суурьшигчид зөвхөн амьдралынхаа хэрэгцээг хангахыг л зорьж байлаа. Бичиг хэрэг, уран зохиолын ажлыг ямар ч ашиггүй, ёс суртахуунгүй зүйл гэж үзэж байв. Протестант зонхилсон хойд хэсэгт хүнд хүчир ажил хийж, эд зүйлс ихтэй болохыг бурханы ивээл хэмээн үздэг байлаа. Нью-Йорк, Филадельфия зэрэг хотын худалдаачид мөнгөө үржүүлэхийг, өмнөд хэсгийн фирмэрүүд их газартай болохыг зорьж байсан. Колоны хүн ам 17-р зууны дунд үед мэдэгдэхүйц хэмжээгээр өсчээ. 1647 онд Массачусет-д 50-аас дээш өрхтэй сууринд сургууль байгуулж эхэлсэн байна. Алдартай Иале, Харвард, Мори болон Вильям коллежууд шашны номлогчдыг бэлтгэхээр байгуулагдсан байна. 1640 онд Bay Psalm Book гэх анхны Америкийн ном хэвлэгдлээ. 1700 оны эхээр сонин гарч эхэллээ. Европоос ном ирэхэд колончлогчдын дунд улс төрийн болон шашны зөрчилдөөн үүсч байлаа.

\* М.Хурметхйн - доктор, профессор

Метафизик яруу найрагчид

Бурхан тэнгэр хүний өдөр тутмын амьдралыг харж байдаг гэсэн пуританы үзэл санаа яруу найрагт нэвтрэн ирсэн байна. 1650 онд Anne Bradstreet шашны бясалгалын яруу найраг хэвлүүллээ. Edwara Taylor английн шашны яруу найрагч John Donne, George Herbert нар уран зохиолын арга барил, уран сэтгэмжтэй яруу найраг бичсэн боловч хэвлүүлээгүй ажээ. Эдгээр зохиолчдыг "Метафизик" яруу найрагчид гэж нэрлэдэг.

Соён гэгээрлийн нөлөөлөл

Соён гэгээрэл гэгдэх философийн урсгал 18-р зуунд Европод өрнөхөд түүний оновчтой логик болон хүний эрхийн үзэл санаа Шинэ Ертөнцөд түргэн тархаж байлаа. Филадельфийн хэвлэлийн бизнесмэн Benjamin Franklin /1706-1790/ соён гэгээрлийн сэтгэлгээний үлгэр дууриал байлаа. Тэрээр зохиолч, судлаач, шинийг бүтээгч, философич, улс төрч тусгаар тогтнолын тэмцлийн үед дипломатч байсан ажээ. 1731-1759 оны хоорондох Franklin-ий амьдралын намтар нь мэргэн ухааны ухаалаг зөвлөгөөгөөр дүүрэн байдаг. 1750-аад онд Шинэ Ертөнцөд хангалттай олон сонин сэтгүүлийн хэвлэлийн газар /гэгээрлийн үзлийг тарааж түгээхэд/ уг үзэл бодол нь колончлогчдын Британы засаглалын эсрэг тэмцэхэд зоригжуулсан юм. 1776 онд бичигдсэн Тусгаар тогтнолын тунхаглалд колончлогчдын байр суурь тодорхойлогдсон байлаа. Тусгаар тогтнолын Тунхаглалыг боловсруулахад Виржиниа нутын том газар эзэмшигч, хуульч Thomas Jefferson /1743-1826/ чухал үүрэг гүйцэтгэсэн. Jefferson хэдийгээр мэргэжлийн зохиолч биш боловч түүний гоц ухаан, цэц мэргэн хэллэг нь тусгаар тогтнолын тунхаглалыг үргэлжилсэн үгийн сод бүтээл болгосон байна.

1783 онд Тусгаар тогтнолыг зарласаны дараа Jefferson Үндсэн хуульд хүний эрхийг хамгаалах заалт оруулав. Jefferson Америкийн 3 дах ерөнхийлөгчөөр сонгогдсон юм. Тусгаар тогтнолоо олсоноор дайнд зориулж байсан хүч чадлаа шинэ Нэгдсэн Улс байгуулах үйл ажиллагаанд зориуллаа. Үндэсний соёл урлагийг хөгжүүлэх нь ч үүнд хамаарч байв. Өмнө нь Европоос ном зохиол, жүжиг импортлон авдаг байсан колочлогчид одоо Америкийн зохиолчид тэр хэмжээий америк хэв шинжийн зохиол бичнэ гэдэгт итгэж байлаа. Мэдээж шинэ уран зохиол тийм ч хурдан үүсэн бий болсонгүй. Анхны америкийн жүжгүүд ихэнхдээ хайр дурлалыг эмэгнэлт сэдэвтэй байв. Ихэнх эмэгтэйчүүд Британы зохиолч Samuel Richardson-ы /1689-1761/ "Памелла ба Клафисса" хэмээх зохиолын маягаар уян сэтгэлт хайрын тухай түүх бичиж байжээ. Америкийн зохиолч Hugh Henry Brackenidge /1748-

1816/ Испани Дон Кихот-той төсөөтэй "Орчин үеийн эр" хэмээх хошин зохиол бичсэн байна. Charles Brockden Brown /1771-1810/ Wieland and Ormand зохиол Англид бичигдсэн "Gothic" зохиолуудыг дуурайсан байлаа. Тэр үеийн тэргүүлэх яруу найрагч нь Philip Freneau /1752-1832/ юм. Тэрээр Америкийн хувьсгалын удирдагчидтай найз нөхөд байсан юм. Френаугийн эхний үеийн яруу найраг нь эх оронч, Америкийн ялалтыг тагтан дуулсан, шинэ ардчилалын бодлогыг тайлбарласан байдаг. Зууны дунд үеэс тэрбээр Европод дэлгэрч байсан "романтик" хэлбэрийг дуурайн байгалийн талаар зохиолууд бичих болжээ..

#### Америк хэв маяг

Френау магадгүй америкийн анхны мэргэжлийн зохиолч байсан авч, түүний нэр алдар төрсөн нутгийн хэмжээнээс хэтэрсэнгүй байна. 1819 онд Нью-Йорк-ын Washington Irving /1783-1859/ бичсэн "The Sketch Book of Geofrey Crayon" цувралыг Европод хүртэл амтархан уншиж байлаа. Нью-Йоркийн "The knickerbocker Wits" дугуйлангийн гишүүн мөн хилийн чанд дах уран зохиолын томоохон төлөөлөгч нартай найз нөхөд байсан нь ертөнцийг үзэх үзэл санаанд нь нөлөөлсөн байна. "The Sketch Book"-д америкийн сонгодог түүх "Rip Van Winkle" ба "The Legend of Sleepy Hollow" багтсан нь хоёр жилийн дараа James Fenimore Cooper /1789-1851/ нь хүмүүсийн анхаарлыг татаж эхлэхэд нөлөөлсөн байна..Тэрээр "Эцсийн Мохикан" " Бугын анчин" болон далайн амьдралын талаар сонирхолтой зохиолуудыг бичсэн. Америк маягийн зохиолын баатрын дүрийг өөрөөр хэлбэл боловсролгүй, байгалийн нөлөөнд амьдардаг, зөн билгээрээ, үнэнч, нийтлэг хүний дүрээр төлөөлүүлэн үзүүлэх нь түүний зохиолын гол онцлог байдаг. 1828 онд Noah Webster Америкийн англи хэл нь Британы англи хэлнээс юугаараа ялгаатайг тодорхойлсон америк англи толь бичиг хэвлүүлээ. 1829 онд Andrew Jackson ерөнхийлөгчөөр сонгогдсон нь америк бодит ардчилалд хүрсэнийг илэрхийлсэн чухал үйл явдал байлаа. Сургуулиуд орон даяар байгуулагдсанаар ард иргэдийн нилээд хэсэг унших бичих чадвартай болсон байлаа. William Holmes McGuffey /1800-1873/ уг сургуулиудад хэрэглэгдэх цагаан толгойн цувралыг хэвлэсэн байна. 1836 оноос хойш "McGuffey Readers" 120 сая гаруй хувь хэвлэгдсэн нь америкчууд үе дамжин нөлөөлж ирсэн үр ашигтай сурах бичиг байжээ.

#### Даврагчид

Нутаг усаа баруун тийш тэлж байсан ч New England дэх зүүн хойт хэсгийн хуучны хотуудад Пуританы нөлөөлөл их байлаа. Шашны ийм байгууллага нь өөрсдийн эсэргүүцэгчдийг бий болгох нь зайлшгүй.

1836 онд Ralph Waldo Emerson "Байгаль" хэмээх нэртэй ном хэвлүүллээ. Уг зохиолд Emerson хүн байгалийг судалж, уялдаатай амьдарсанаар оюун санааны өндөр төвшинд шашны оролцоогүйгээр хүрч болно гэсэн үзлийг дэвшүүлжээ. Дараах жилүүдэд Emersonы өгүүллэгүүдэд түүнийг зөвхөн сэхээтнүүдийн дунд зогсохгүй нийт ард түмний дунд нэр нөлөөтэй хүн болголоо.

Яруу найрагтаа Emerson чөлөөт, тийм төрөл зүйлийг хөгжүүлж, байгалийн уран сэтгэмж, бэлэг тэмдэгийг ашиглаж байв. Түүний уран бүтээл нь тэр үеийн бусад яруу найрагчдад хүчтэй нөлөөлж байжээ. Emersonыг тойрон хүрээлсэн сэхээтнүүдийн дугуйлан үүсч "Даврагсад" гэж нэрлэгдэв. Тус дугуйлангийн авъяастай уран сэтгэгчдийн нэг бол Henry David Thoreau /1817-1862/ Өөрийнхөө туршлага, түүхийг өгүүлсэн "Walden" нэртэй ном бичиж 1854 онд хэвлүүлсэн байна..

#### Уран сэтгэмжийн хүч чадал

Тэр үеийн өөр яруу найрагч зохиолчид оюун ухааны гэгээрлийн талаар бус хүний уран сэтгэмж, сэтгэлийн хөдлөлийг чухалд үзэж байв. Тухайлбал, Edgar Allan Poe /1809-1849/ хөгжмийн хэллэгтэй, гоц уран нөлөөлөлтэй яруу найргийн зохиол бичсэн нь түүнийг Европын романтик яруу найрагчдын өрсөлдөгч болтолоо танил болоход хүргэжээ. 1835 онд "The Pit and the Pendulum", ба "The Fall of the House Usher" зэрэг богино хүүрнэлүүд бичжээ.

1837 онд N.Hawthorne /1804-1864/ өвөрмөц үйл явдлаар дүүрэн "Хоёр дахин хүүрнэгдсэн түүх" ном хэвлүүлэв. Түүний хамгийн алдарт бүтээл "The Scarlet Letter" 1850 онд хэвлэгдсэн байна. Энэ нь Hawthorne-ы зохиолч Herman Melville /1819-1891/ -д гүнзгий нөлөөлсөн ажээ. Баян эцэг нь эдийн засгаар дампуурсан учир Melville төрөл бүрийн ажил хийж байгаад 1839 онд далайн аялалд гарчээ. 7 жилийн дараа задгай тэнгист болсон адал явдлын талаар болон энэ тэндэхийн эсэн бусын далайн боомтын талаар тэмдэглэл хөтөлж эхэлсэн ажээ. Hawthorne-гийн жишээгээр улс төр шашны ёсчлон бичдэг нэгэн. Олон түмэн түүнийг сайшаан зөвшөөрөхгүй байсан ч амьдралынхаа үлдсэн хугацаанд яруу найргаа бичсээр байсан. Тэр үеийн хүмүүст таалагдахгүй байсан уг номууд нь өнөөдрийн хүмүүсийн амтархан уншдаг бүтээлийн нэг юм. 1831 онд хэвлэгдсэн халим загас агнах аялалын талаар өгүүлдэг "Moby Dick" номонд хувь заяа муу санаа, хор хөнөөлийн үнэн нүүр царай, хувь хүний ертөнцийн эсрэг тэмцлийн талаар гүнзгий бичсэн байдаг юм. Уг зохиол нь америкийн уран зохиолын сод бүтээлийн тоонд яах аргагүй ордог юм.

/үргэлжлэл бий/